



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/02/СТА-ОНӨААН

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn

Ахлах аудитор : Б.Дагвасүрэн

Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn

Аудитор П.Ганцолмон

Утас:70157405 Цахим хаяг:ulistaivanaudit@ubaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Санхүүгийн тайлангийн аудитын тодруулга	
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Дотоод хяналт	12
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
4.4 Материаллаг байдал	13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	15
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улаанстай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

“АМЬ-УС” ТРЕЙД ОНӨААН-ЫН
ДАРГА Д.МЯГМАРДОРЖ -д

2022.08.15 № 1302-487

талай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Амь-Ус” трейд ОНӨААН-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын бэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Амь-Ус” трейд ОНӨААН-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



013025482

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгө	5,908,802.16	215,465,626.92
1.1.2	Дансны авлага	61,376,583.11	102,393,058.72
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	808,982.00	
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	93,293,850.40	107,414,365.88
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	161,388,217.67	425,273,051.52
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,237,400,078.54	1,198,942,565.77
1.2.2	Биет бус хөрөнгө	-	147,272.73
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө		
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,237,400,078.54	1,199,089,838.50
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,398,788,296.21	1,624,362,890.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1.	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Татварын өр	67,351,337.22	53,345,334.28
2.1.1.4	НДШ - ийн өглөг	13,116,272.32	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,235,640.52	3,604,939.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	81,703,250.06	56,950,273.47
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,304,445,614.16	1,304,445,614.16
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,304,445,614.16	1,304,445,614.16
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,386,148,864.22	1,361,395,887.63
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	310,884,631.60	310,884,631.60
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	202,588,036.23	202,588,036.23
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	603,406,511.21	603,406,511.21
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	27,805,059.95	27,805,059.95
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,132,044,807.00)	(881,717,236.60)
2.3.11	Эздийн өмчийн дүн	12,639,431.99	262,967,002.39
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,398,788,296.21	1,624,362,890.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	633,402,490.39	1,232,264,535.75
2	Борлуулалтын өртөг	665,516,432.87	797,885,426.57
3	Нийт ашиг (алдагдал)	(32,113,942.48)	434,379,109.17
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	139,155,438.43	153,210,990.51
11	Санхүүгийн зардал	-	3,026,374.26
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(171,269,380.91)	278,141,744.40
19	Орлогын татварын зардал	-	27,814,174.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(171,269,380.91)	250,327,570.40
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(171,269,380.91)	250,327,570.40

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	310,884,631.60	202,588,036.23	603,406,511.21	27,805,059.95	(1,132,044,807.00)	12,639,431.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	310,884,631.60	202,588,036.23	603,406,511.21	27,805,059.95	(1,132,044,807.00)	12,639,431.99
4	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
9	2020 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	310,884,631.60	202,588,036.23	603,406,511.21	27,805,059.95	(1,132,044,807.00)	12,639,431.99
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	310,884,631.60	202,588,036.23	603,406,511.21	27,805,059.95	(1,132,044,807.00)	12,639,431.99
12	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	250,327,570.40	250,327,570.40
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
17	2021 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	310,884,631.60	202,588,036.23	603,406,511.21	27,805,059.95	(881,717,236.60)	262,967,002.39

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	657,992,483.41	1,286,826,348.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	618,575,634.30	1,223,825,819.85
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого		
1.1.6.	Бусад мөнгөн орлого	39,416,849.11	63,000,528.81
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	668,070,573.02	1,077,269,523.90
1.2.1	Ажиллагчдад төлсөн	331,300,609.72	373,773,401.26
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,773,037.52	126,769,461.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	65,448,713.00	218,912,450.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	82,180,153.07	50,030,465.36
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	54,572,486.30	63,214,528.88
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	33,699,135.14	169,052,069.36
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	1,119,170.00	850,050.00
1.2.9.	Бусад мөнгөн зарлага	18,977,268.27	74,667,098.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	(10,078,089.61)	209,556,824.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Эзэл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Эзэл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-10,078,089.61	209,556,824.76
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-10,078,089.61	209,556,824.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	15,986,891.77	5,908,802.16
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	5,908,802.16	215,465,626.92

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	805,584,100.00	804,671,871.30	933,356,800.00	954,122,791.34	-20,765,991.34	102%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	805,584,100.00	804,671,871.30	933,356,800.00	954,122,791.34	-20,765,991.34	102%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,084,100.00	796,417,456.30	914,856,800.00	912,596,015.34	2,260,784.66	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,582,600.00	415,622,111.24	444,849,800.00	449,957,646.27	-5,107,846.27	101%
210101	Үндсэн цалин	409,082,600.00	408,182,111.24	433,349,800.00	441,094,919.00	-7,745,119.00	102%
210105	Гэрээт ажлын хөлс	11,500,000.00	7,440,000.00	11,500,000.00	8,862,727.27	2,637,272.73	77%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,801,500.00	55,203,466.57	61,907,000.00	61,535,751.72	371,248.28	99%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,400,000.00	91,130,207.85	98,650,000.00	52,144,128.79	46,505,871.21	53%
210301	Гэрэл, цахилгаан	50,200,000.00	59,335,907.85	60,150,000.00	24,136,136.07	36,013,863.93	40%
210302	Тулш, халаалт	23,200,000.00	31,794,300.00	38,500,000.00	25,290,265.45	13,209,734.55	66%
210304	Байрны гүрээс				2,717,727.27	-2,717,727.27	
2104	Хавгамж, бараа материалын зардал	53,500,000.00	48,733,091.49	53,000,000.00	46,249,997.84	6,750,002.16	87%
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	1,469,147.27	3,000,000.00	950,200.01	2,049,799.99	32%
210402	Тээвэр, шатахуун	50,500,000.00	45,229,494.28	50,000,000.00	40,399,744.42	9,600,255.58	81%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,034,449.94		4,900,053.41	-4,900,053.41	
2105	Нормативт зардал	20,000,000.00	7,443,000.00	8,000,000.00	727,954.54	7,272,045.46	9%
210502	Хоол, хууч	20,000.00	7,443,000.00	8,000,000.00	727,954.54	7,272,045.46	9%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,500,000.00	53,048,365.72	69,700,000.00	133,226,995.48	-63,526,995.48	
210601	Багач, техник, хэрэгсэл	9,000,000.00	5,974,655.73	9,000,000.00	10,866,636.36	-1,866,636.36	
210602	Тавилга	32,000,000.00	37,457,229.53	45,000,000.00	112,705,131.84	-67,705,131.84	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,500,000.00	9,616,480.46	12,700,000.00	9,655,227.28	3,044,772.72	76%
210604	Урсгал засвар	3,000,000.00		3,000,000.00		3,000,000.00	0%
2107	Томилголт, зочны зардал	4,500,000.00	1,667,200.00	4,500,000.00	64,000.00	4,436,000.00	
210702	Дотоод албан томилголт	4,500,000.00	1,667,200.00	4,500,000.00	64,000.00	4,436,000.00	1%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,650,000.00	1,497,427.27	4,450,000.00	1,073,118.00	3,376,882.00	24%
210803	Даатгалын үйлчилгээ	2,500,000.00	1,017,427.27	2,500,000.00	850,050.00	1,649,950.00	34%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	650,000.00	480,000.00	650,000.00	223,068.00	426,932.00	34%
210807	Газрын төлбөр	1,500,000.00		1,300,000.00		1,300,000.00	0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,150,000.00	122,072,586.16	169,800,000.00	167,616,422.70	2,183,577.30	99%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	12,153,602.99	7,500,000.00	57,241,500.02	-49,741,500.02	
210902	Үндсэн хөрөнгийн ашигдал	83,000,000.00	104,019,383.17	91,000,000.00	94,941,876.41	-3,941,876.41	104%
210903	Үндсэн хөрөнгийн татвар	1,650,000.00		2,500,000.00		2,500,000.00	0%
210904	Сургалтын зардал	3,000,000.00	250,000.00	2,000,000.00	160,000.00	1,840,000.00	8%
210905	Хүү торгууль хөнгөлөлтийн зардал				3,026,374.26	-3,026,374.26	
210906	Баар ёслолын зардал				6,542,945.45	-6,542,945.45	
210907	Ариун цэврийн зардал				3,315,327.29	-3,315,327.29	
210908	Үндэслэлийн цайны зардал				727,954.54	-727,954.54	
210909	Засвар үйлчилгээ	9,000,000.00	1,563,000.00	45,000,000.00	660,444.73	44,339,555.27	1%
210910	Зар сурталчилгаа	2,000,000.00	200,000.00	1,000,000.00		1,000,000.00	0%
210911	Найвтаргүй авлага	2,000,000.00		2,000,000.00		2,000,000.00	0%
210912	ТУЗ-ийн зардал	3,100,000.00		3,100,000.00		3,100,000.00	0%
210913	Усны шинжилгээ	2,000,000.00	847,000.00	2,000,000.00		2,000,000.00	0%
210914	Лабораторийн зардал	1,500,000.00	616,100.00	2,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	50%
210915	Усны зохицуулах зөвлөл	3,950,000.00		3,950,000.00		3,950,000.00	0%
210916	Эрүүд мэндийн үзлэг	450,000.00	253,500.00	450,000.00		450,000.00	0%
210917	Богдын гол дэвгүүрх с/шугаманд тулгуур багануудад хагалбар хийх	4,800,000.00	2,170,000.00	4,800,000.00		4,800,000.00	0%
210918	Ус ашиглалтын татвар	1,200,000.00		2,500,000.00		2,500,000.00	0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,500,000.00	8,254,415.00	18,500,000.00	41,526,776.00	-23,026,776.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,500,000.00	8,254,415.00	18,500,000.00	41,526,776.00	-23,026,776.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,500,000.00	7,857,415.00	18,000,000.00	22,977,276.00	-4,977,276.00	128%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		397,000.00	500,000.00	18,549,500.00	-18,049,500.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,986,891.80	-	5,908,802.16		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,908,802.16	-	215,465,626.92		

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ийн Хэрэглэгчдийг унд ахуйн стандарт шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир шингэнийг татан зайлуулж байгаль экологид нөлөөлгүйгээр цэвэршүүлэх зорилготой гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Улсын төсөвт үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн гишүүдийн тоо 1 ба 100 хувь төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН нь Завхан аймгийн Улиастай хотод үйл ажиллагаагаа явуулдаг 100 хувь орон нутгийн өмчит аж ахуй нэгж юм.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд цалин, урамшуулал авдаггүй.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт нь Монгол улсад мөрдөгдөг Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам заавар, НББОУС, СТОУС-д нийцсэн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн гэхэд эргэлзэж байна.

Санхүүгийн Лидэр программ ашигладаг бөгөөд санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	5,908.8	215,465.6	209,556.8
Дансны авлага	61,376.6	102,393.0	41,016.4
Татвар, НДШ-ийн авлага	808.9	-	-808.9
Бараа материал	93,293.8	107,414.3	14,120.5
Үндсэн хөрөнгө	1,237,400.0	1,198,942.5	-38,457.5
Биет бус хөрөнгө	-	147.2	147.2
Нийт хөрөнгө	1,398,788.1	1,624,362.6	225,574.5
Татварын өр	67,351.3	53,345.3	-14,006.0
НДШ - ийн өглөг	13,116.3	-	-13,116.3
Бусад богино хугацаат өр төлбөр	1,235.6	3,604.8	2,369.2
Бусад урт хугацаат өр төлбөр	1,304,445.6	1,304,445.6	-
Өмч: - төрийн	310,884.6	310,884.6	-
Нэмж төлөгдсөн капитал	202,588.0	202,588.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	603,406.5	603,406.5	-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	27,805.0	27,805.0	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	-1,132,044.8	-881,717.2	250,327.6
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн дүн	1,398,788.1	1,624,362.6	225,574.5

Тус байгууллага нь Хаан банк, Хадгаламж банк, Хас банкинд тус бүр нэг нэг төгрөгийн харилцах дансдуудтай бөгөөд мөн Бэлэн мөнгөний кассаар мөнгөн хөрөнгийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацааны эцэст Хаан банкны харилцах дансны үлдэгдэл 189,084,133.97 төгрөг, Хадгаламж банкны харилцах дансны үлдэгдэл 6,610,076.27 төгрөг, харин Хас банкны харилцах дансны үлдэгдэл 19,275.0 мянган төгрөг, Бэлэн мөнгөний кассын үлдэгдэл 496,372.47 төгрөг байсан.

Тус байгууллага Хаан банкины төгрөгийн харилцах дансаараа орлогоо төвлөрүүлдэг бөгөөд тайлант хугацаанд 1,230,550.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 1,042,2830.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан.

Хадгаламж банкины төгрөгийн харилцах дансаараа бага хэмжээний орлогыг төвлөрүүлдэг бөгөөд тайлант хугацаанд 23,936.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 18,646.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан.

Хас банкины төгрөгийн харилцах дансаараа тайлант хугацаанд 43,747.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 26,046.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан.

Бэлэн мөнгөний кассын үлдэгдэл тайлант хугацааны эцэст 496.3 мянган төгрөг байсан ба 6,756.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 8,457.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан байна.

Дансны авлагын үлдэгдэл өмнөх оноос 41,016.4 мянган төгрөгөөр өссөн нь дотоодын байгууллагаас авах авлага, дотоод хэрэгцээ тооцооны авлага дансдуудын өсөлт нөлөөлсөн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 14,120.5 мянган төгрөгөөр өссөн нь бараа, бүтээгдэхүүн, хангамийн материал дансдын өсөлт нөлөөлсөн байна. Бараа материал дансанд түүхий эд материал, бараа, бүтээгдэхүүн, хатуу түлш, лабораторийн шил сав, эм реактив, машины сэлбэг хэрэгсэл, хангамжийн материал багтдаг байна.

Тайлант хугацаанд 185,061.1 мянган төгрөгийн бараа материалыг бэлтгэж, 170,940.6 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 38,457.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдэлтэй холбоотой байна. Үндсэн хөрөнгө дансанд газар, барилга, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил дансдууд багтдаг.

Тайлант хугацаанд 56,631.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэж, 94,794.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан.

Татварын өрийн үлдэгдэл 53,345.3 мянган төгрөг болж өмнөх оноос 14,006.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацааны татварын өрийн үлдэгдэл НӨАТ-ын өр 21,477.2 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 4,669.6 мянган төгрөг, Ус ашигласны татварын өглөг 4,377.4 мянган төгрөг байна.

Бусад урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,304,445.6 мянган төгрөг өнөөг хүртэл хөдөлгөөнд ороогүй байсан нь нилээд хэдэн жилийн өмнөөс үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой өрийн үлдэгдлээс үүссэн байна. Энэхүү дансны үлдэгдэлийг барагдуулах, санхүүгийн тайлангаа цэвэрлэх талаар компанийн удирдлагууд дорвитой арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.

Тус байгууллага нь 100 хувь төрийн өмч бөгөөд хөрөнгийн хэмжээ 310,884.6 мянган төгрөг бөгөөд тайлант хугацаанд 250,327.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба хуримтлагдсан алдагдал нь дээрх дүнгээр буурсан.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Амь-Ус трейд” ХХК ОНӨААН байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 940,0 сая төгрөгөөр, нийт зардлыг 933.3 сая төгрөг байхаар тогтоосон байна.

Өмнөх онд тус байгууллага нь 171,269.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол тайлант онд 250,327.5 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад “Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-тэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Амь-Ус трейд” ХХК ОНӨААН нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 12,322.6 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1,232,264.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,322.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 8,625.8 мянган төгрөгөөр тогтоосон.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 5 байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ибаримтын бүрдүүлэлт, хөрөнгийн ашиглалт, хөрөнгийн тооллого, санхүүгийн тайлангийн хоорондын зөрүү, татвар болон санхүүгийн тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүнүүд, авлага, өглөгийн тулган баталгаажуулалт, ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилт, бэлэн мөнгөний кассын тайлангийн архивлалт зэрэгт анхаарч ажиллах

8. Аудитын илрүүлэлтээр алдаа, зөрчил илэрсэнгүй.

Аудитаар нийт 1,402,548.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж зөвлөмж хүргүүллээ.

8.1 Залруулсан алдаа байхгүй.

8.2 Төлбөрийн акт өгөгдөөгүй.

8.3 Албан шаардлага өгөгдөөгүй.

8.4 Зөвлөмж:

1. Засгийн газрын 43 тогтоолтой холбоотойгоор:

- ✓ Илрүүлэлт: НАА-90-н жилийн ойн хүлээн авалт нэрээр 2021.10.15-ний өдрийн Алтан ХХК руу шилжүүлсэн 4,000.0 мянган төгрөг, 2021.10.11-ний өдөр СИМАТАЙПРОМОШН ХХК руу шилжүүлсэн Дэвтэр бал тэмдэглэлийн дэвтэрний үнэ 2,026.2 мянган төгрөг, нийт 6,026.2 төгрөгийг зарцуулсан нь 2021 оны 2 дугаар сарын 43 Засгийн газрын тогтоолын 1.6. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх заалтыг зөрчсөн.
- ✓ Өгсөн зөвлөмж: Тогтоолыг мөрдөн ажиллах
- ✓ Илрүүлэлт: Шинэ хүн мэндлэх, буяны ажил, буцалтгүй тусламж, эмнэлэгт хэвтэх гэх мэтээр нийт 21 удаагийн үйлдлээр нийт 2,048.9 мянган төгрөгийг зарцуулсан нь 2021 оны 2 дугаар сарын 43 Засгийн газрын тогтоолын 1.1 үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах заалтыг зөрчсөн.
- ✓ Өгсөн зөвлөмж: Тогтоолыг мөрдөн ажиллах
- ✓ Илрүүлэлт: Тус байгууллагын удирдлага нь фитнесийн тоног төхөөрөмж гэх 12 ширхэг 10,814.0 мянган тоног төхөөрөмжийг 5-р сард худалдан авсан нь энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх заалтыг зөрчсөн
- ✓ Өгсөн зөвлөмж: Тогтоолыг мөрдөн ажиллах

2. Ибаримтын талаар:

- ✓ Илрүүлэлт: Тайлант хугацаанд 369,471.5 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр мөнгө шилжүүлсэн боловч 290,231.5 мянган төгрөгийн и баримт шивүүлж 79,239.9 мянган төгрөгийн зардал огт баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж,

борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.”; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

- ✓ **Өгсөн зөвлөмж:** Байгууллагаас гарсан худалдан авалт бүрт ибаримт бүрдүүлж зарцуулалт хийж хэвших

3. Насжилт өндөртэй үрт хугацаат өр төлбөрийн талаар:

- ✓ **Илрүүлэлт:** Он удаан жил хөдөлгөөнд ороогүй 1,304,445.6 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгасаар байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; зэрэг заалтыг тус тус зөрчсөн байна.
- ✓ **Өгсөн зөвлөмж:** Хөдөлгөөнд орохгүй байгаа санхүүгийн тайланд тусгагдсан авлага, өглөгийн тухай бүр нь баталгаажуулж данснаас хасах, хаах арга хэмжээ авах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	5	1,402.4							5	1,402.4
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	0									0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
	НИЙТ ДҮН	5	1,402.4							5	1,402.4

